


Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2020 оны ... дугаар сарын ... ны өдрийн
дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

A/235



**БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГАЛЫН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч байгууллагын нэр:

Объектын нэр:

Байгууллагын регистрийн дугаар:

Захирлын нэр, утасны дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:

Шаардлага хангасан
асуултын тоо

гал түймрийн онц аюултай

гал түймрийн аюултай 1 дүгээр
зэрэглэл

Шаардлага хангаагүй
нийт тоо

гал түймрийн аюултай 2 дугаар
зэрэглэл

гал түймрийн аюултай 3 дугаар
зэрэглэл

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД

№	Хууль тогтоомж, стандарт, норм, нормативын зүйл, заалт	Асуултууд	Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй	Төлөвлөгөөт хяналт шалгалт	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.2-р зүйл	Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгасан эсэх;				
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3-р зүйл	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримталсан эсэх;				
3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.7-р зүйл	Барилга байгууламж, үйлдвэрийн технологид хэрэглэх бодис, материалын гал түймрийн аюулын зэрэглэлийг итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулсан эсэх;				
4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.3-р зүйл	Аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хяналтын бүртгэл хөтөлсөн эсэх;				
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.5-р зүйл	Барилга байгууламж болон үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдалд гал түймрийн аюулын үнэлгээ хийлгэсэн эсэх;				
6	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-р заалт	Тухайн барилга байгууламжид гал түймэр унтраах автомашин хүрэлцэн очих зам, талбай чөлөөтэй эсэх;				
7	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дах заалт	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэлд техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангасан эсэх				

8	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дахь заалт	Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан эсэх				
9	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7-р заалт	Барилгын материал, хийц, бүтээц галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичигт заасан гал тэсвэржилтийн зэргийг хангасан, итгэмжлэгдсэн лабораториос олгосон гал түймрийн аюулын ангиллын гэрчилгээтэй эсэх;				
10	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8-р заалт	Зориулалтаас хамаарч барилга нэг бүрийн болон нийтийн тусгай аврах хэрэгслээр тоноглогдсон эсэх;				
11		2.2.1. Нутаг дэвсгэр, барилга байгууламж, өрөө тасалгаа, аврах зам, гарц;				
12		2.9.Шөнийн цагаар хүмүүс тогтмол байрлах (24 цагийн хүүхдийн цэцэрлэг, дотуур байр, сургууль, эмнэлэг г.м) байгууллагад өдрийн болон шөнийн цагаар аврах үйл ажиллагаа явуулах хувилбарт төлөвлөгөөтэй байна.				
13	Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоол "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2-р зүйл Галын аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага	2.14. Гал унтраах автомашин явах зам, гарцыг түр хугацаагаар хаах шийдвэр гаргасан албан тушаалтан энэ талаар тухайн төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагад мэдэгдэж, зам, гарцыг хаасан хугацаанд тойрч гарах замын чиглэлийг зааж, саадыг даван гарах боломжоор хангаж, усны эх үүсвэрт хүрэх гарцыг гаргасан байна.				
14		2.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байнга байрлах барилга байгууламжид байрлуулсан гэрлэн дохионы хэрэгсэл нь дуут дохиотой хавсарсан, гэрлэн дохионы анивчих давтамж нь 5 Гц-ээс ихгүй байна. Гал түймрийн талаар мэдээлэх гэрэлтэж харагдах самбар нь хүний хараанд тохирсон тод ногоон гэрэлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байнга байрлах барилга байгууламжид ажиллах ажилтан нь гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах, аврах ажиллагааны чиглэлээр тусгай сургалтад хамрагдаж,				

		зааварчилгаа авсан байна.				
15		2.17.Барилга байгууламжийг түрээслэх гэрээнд тухайн барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах шаардлага, хариуцлагын талаар заавал тусгана.				
16		2.15. Галын аюулгүйн шаардлагын дагуу барилга байгууламжийн мод, төмөр, хийц бүтээц, даавуу, хөшиг зэрэг шатамхай эд зүйлийг галд тэсвэртэй бодист түрхлэг, нэвчилгээ хийсэн байх бөгөөд тухайн бодисын үйлчлэлийн хугацаа дууссаны дараа дахин боловсруулалт хийнэ. Галд тэсвэртэй бодисын үйлчлэлийн чанарыг техникийн үзүүлэлтэд заасан хугацаанд болон жилд 1 удаа шалгана.				
17	“Барилга байгууламжийн галын аюулгүй байдал” БНБД 21-01-02-ийн 7.7 дахь заалт	Зоорь ба хагас зоорийн давхарт тусгайлан авч үзсэнээс бусад нөхцөлд шатамхай хий ба шингэн мөн хялбар авалцан асах материал агуулдаг буюу хэрэглэдэг өрөө тасалгаа байрлуулахыг зөвшөөрөхгүй				
18	“Барилга байгууламжийн галын аюулгүй байдал” БНБД 21-01-02-ийн 6.9 дахь заалт	Авран хамгаалах ба аврах гарцын байдал холбогдох шаардлага хангасан эсэх Гарцыг дараах нөхцөлд аврах зориулалттай гэж тооцно. а\ Нэгдүгээр давхрын өрөөнөөс гадагш гарах: -шууд гарах -коридор дамжиж гарах -гонх \хөлийн өрөө\ өөр дамжиж гарах -шатны хонгилоор дамжиж гарах -коридор ба шатны хонгилоор дамжиж гарах б\ Нэгдүгээр давхраас бусад аль ч давхрын өрөөнөөс: -шатны хонгилд буюу 3-р төрлийн шатанд шууд гарах				
19	Олон нийт иргэний барилга /БНБД 31-03-03/*/11-ын 3 дугаар зүйл	3.4. Сургуулийн өмнөх насны хүүхдийн барилгын хүчин чадал, давхрын хязгаар, барилгын гал тэсвэршилтийн зэрэг хоорондын хамаарал нь 10 дугаар хүснэгтийн дагуу төлөвлөгдсөн эсэх; Тайлбар: 1-д (А) Цэцэрлэгийн 3 хүртэл давхар барилга гал тэсвэршилтийн II-оос доошгүй зэрэгтэй байх ёстой. 3.5. (А) Цэцэрлэгийн тусгай зориулалтын барилгын гал тэсвэршилтийн зэрэг хоёроос				

		багагүй, давхар нь 2-оос ихгүй байхаар тооцож төлөвлөнө.				
		3.6. (А-Е) Цэцэрлэг, бага сургууль, ажилчдын сууцыг нэгдсэн эзэлхүүнээр төлөвлөвөл цэцэрлэгийн барилгад бие даасан гарц төлөвлөнө. Гэхдээ сургууль, сууцны өрөөнөөс хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх гарцыг цэцэрлэгийн барилгаар дамжихаар төлөвлөхийг хориглоно.				
		Гал тэсвэршилтийн IV зэрэгтэй барилгад багш нарын сууцыг, сургууль, цэцэрлэгийн барилгын өрөөнөөс тусгаарлах хамар хана, хучилтын гал тархах хязгаар 40 см байх үед галд тэсвэршилтийн хязгаар 0.75 цаг байна. Цэцэрлэг, сургууль хоёрыг хооронд нь галаас хамгаалах ханаар тусгаарласан нөхцөлд гал тэсвэршилтийн зэргийг тус бүрийнх нь хүчин чадалтай уялдуулан тогтооно.				
		3.7. (А) Цэцэрлэгийн 70-аас дээш хүүхдийн багтаамжтай барилгад залгаж барих верандын гал тэсвэршилтийн зэрэг үндсэн барилгатайгаа адил байна. Цэцэрлэгийн барилгад байх хөгжмийн анги, биеийн тамирын хичээлийн танхим, аврах гарцын хана, тайзны заслал чимэглэлийг шатдаггүй материалаар хийнэ.				
		3.8. (А) Цэцэрлэгийн барилгын ханыг органик биш материалаар дулаална.				
		3.9. (А) Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт сургуулийн барилгын хүчин чадал, давхрын хязгаар, гал тэсвэршилтийн зэрэг хоорондын хамаарлыг 11 дүгээр хүснэгийн дагуу тогтооно төлөвлөсөн эсэх;				
20	Гал унтраах автомат тоног төхөөрөмж, галын дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	Тухайн барилга байгууламжид гал унтраах автомат тоног төхөөрөмж төлөвлөгдсөн эсэх,	- усны насос, усан сангийн байнгын ажиллагаа хэвийн эсэх			
			-Удирдлагын зангилааны ажиллагаа хэвийн эсэх			
21	Гал унтраах автомат тоног төхөөрөмж, галын	Галын дохиоллын хэрэгсэл төлөвлөгдсөн	-Утаа мэдрэгч			
			-Дулааны			
			-Удирдлагын самбар			

	дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	эсэх мэдрэгч	-гар мэдээлэгч				
22	Усан хангамж, гадна сүлжээ ба байгууламж /БНБД 40-02-16/	Гал түймэр унтраах галын дотор болон гадна усан хангамж	-Гал унтраах хушуу				
23			-Галын хоолой				
			-Холбох тотго				
			-Барилгын гадна гидрант төлөвлөгдсөн эсэх				
24	Агаар сэлгэлт ба кондиционер /БНБД 41-01-02/-ийн 7 дугаар зүйл	Агаарын хаялт ба утаа зайлуулах системийн хэвийн ажиллагааг хангасан эсэх					
25	Гал түймрээс. Аж ахуй нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл MNS5566:2020 стандарт	Тухай барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл стандартын дагуу байгаа эсэх.					
26	Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд MNS GOST R 12.2.143 : 2013	Энэхүү стандартын холбогдох заалтуудыг хангаж байгаа эсэх					
27		4.2.1 Дээврийн уналт нь 1 метрээс их тохиолдолд галын шат төлөвлөнө. Аврах шат нь дараах нөхцлийг хангаж байх шаардлагатай. Гишгүүрийн өргөн 0,25 метрээс багагүй, марш болон талбайн хязгаарлагчийн өндөр 1,2 метрээс багагүй, шатны өргөн 0,9 метрээс багагүй байна					
28	Гал түймрээс хамгаалах. Барилгын гадна талын суурин шат. Дээврийн хязгаарлагч. Техникийн шаардлага. MNS 6575 : 2016	4.2.2 /10-20/ метр хүртэл өндөрт гарах буюу /1-20/ метр хүртэл өндрийн зөрүүтэй дээврийн уналтын хэсэгт ГШ1 төрлийн шат төлөвлөнө.					
29		4.2.3 20 метрээс дээш өндөрт гарах, 20 метрээс илүү өндрийн зөрүүтэй дээврийн уналтын хэсэгт ГШ2 төрлийн галын шатыг төлөвлөнө.					
30		4.2.4 Шатны марш, шатны					

		маршийн хашлагын хоорондох зай 75 мм-ээс багагүй өргөнтэй байна.				
31		4.2.6 Тэгш өнцөгт талбай бүхий босоо шатны дээвэрт гарах хэсгийн урт нь 0,8 метрээс багагүй байна.				
32		4.2.7 Босоо шатны доод хэсгийг хөдөлгөөнт байдлаар хийж болох бөгөөд энэ тохиолдолд байнгын ажлын байрлалд байлгана..				
33		4.2.8 Дээврийн хязгаарлагчийг талбай бүхий шатнаас буух гарцтай давхцахааргүй хийнэ.				
34		4.2.9 Барилга байгууламжийн гадна байрлуулсан шатанд ашиглалтын явцад хийцлэлд хурц ирмэг гараагүй байна.				
35		4.2.10 Гадна төмөр шатыг 2-оос багагүй удаа давхарлан будсан байна.				
36		4.2.11. Шатны хийцлэл, бэхэлгээ зэргийг холбогдох стандартын дагуу туршиж шалгасан байх ба туршилтын ачааллыг даахаар бат бэх хийгдсэн байна.				
37		4.2.1 Дээврийн уналт нь 1 метрээс их тохиолдолд галын шат төлөвлөнө. Аврах шат нь дараах нөхцлийг хангаж байх шаардлагатай. Гишгүүрийн өргөн 0,25 метрээс багагүй, марш болон талбайн хязгаарлагчийн өндөр 1,2 метрээс багагүй, шатны өргөн 0,9 метрээс багагүй байна				
38		Тухайн барилга байгууламжийн цахилгаан шугам сүлжээний угсралт, цахилгаан тоног төхөөрөмжийн төлөвлөлт нь галын аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх,				
39	Цахилгаан байгууламжийн дүрэм /БД 43-101-03/-ийн 2.1.8, 2.1.9 дэхь заалт	Цахилгаан утас ба кабелийн салбарлага, холболтыг шахуурга, гагнуур, гагнаас, гагнаас буюу боолтон хавчаар зэргийг ашиглан мөрдөж байгаа “Цахилгаан техникийн ажил БНБД 3 05.06.90-ийн дагуу гүйцэтгэнэ. Дамжуулах утас ба кабелийн салбарлага, холболтыг хийдээ залгалтын судлыг дахин хийж болзошгүй байдлыг тооцож, нөөцтэй тайрахаас гадна үзлэг, засвар хийх боломжтой байвал зохино.				
40		Агаарын шугамын тусгаарлах шон дээр байрлах дамжуулах утаснаас бусад тохиолдолд кабель ба утасны залгаас ба салбарлагыг холболт ба салбарлагын хайрцаг, тусгаарлагч				

		бүхий корпус дахь холболтын ба салбарлагын хавчаар, барилгын тусгай хийцийн нүх, цахилгаан төхөөрөмж, машин, аппаратын арьсны дотор хийж гүйцэтгэх ёстой.				
41	Сургууль, /цэцэрлэг/-ийн анх төлөвлөгдсөн хүчин чадал (сурагчид, оюутны тоо)					
42	Одоо байгаа сурагчид оюутны тоо					
43	Улсын комисст хүлээн авсан эх					
44	Бусад					

БАТАЛГААЖУУЛАЛТ	
Хяналтын чиглэл, албан тушаалтны нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуй нэгж байгууллагын эрх бүхий албан тушаалтан
/Овог нэр/	/Овог нэр
/Гарын үсэг, тэмдэг /	/Гарын үсэг, тэмдэг/

---oOo---